

**ХУУЛЬ САХИУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИНЭЧЛЭЛД ХҮНИЙ НӨӨЦИЙН
СЭТГЭЛГЭЭНИЙ ШИНЭЧЛЭЛИЙН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ**

Я.Цэлмэн

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх

ажиллагааны онол, тактикийн тэнхимийн ахлах багш

Товчлол: Хууль сахиулах үйл ажиллагаанд шинэчлэл хийх нь хүний нөөцийн сэтгэлгээнд шинэчлэл хийхээс эхлэх ёстой. Нэгэнт шинэчлэлийг хүлээн авахаас ил ба далдаар эсэргүүцэх болсон зарим удирдах бүрэлдэхүүн, алба хаагчдад зорилтот бодлогыг баримтлах нь шинэчлэлийг хэлбэрийн бус агуулгын түвшинд хүргэнэ.

Abstract: Innovation of law enforcement activities must begin with the innovation of human resource mindset. The policy of cleaning the system from executives and officials who are openly or secretly protesting the innovation will contribute to conducting the innovation at the level of content.

Хууль сахиулах үйл ажиллагаа гэдэг манай улсын тухайд шинэ нэр томъёолол. “Гэмт хэрэг илрүүлэх хойшлуулашгүй ажиллагаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, гүйцэтгэх ажил, нийгмийн хэв журам сахиулах, нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаанууд “хууль сахиулах үйл ажиллагаа” гэсэн ойлголтод багтаж хууль сахиулагчийн эрх зүйн байдлыг тусгайлсан хуулиар тогтооно”¹ гэжээ.

Энэ шинэ ухагдхуун дээр шинэчлэл гэсэн ухагдхуун нэмэгдэж байна. Аливаа шинэчлэлийг аль ч салбарт хүн хэрэгжүүлдэг. Тэр тусмаа тухайн салбарын тэргүүний мэргэжилтнүүд.

Харин шинэчлэл нь өөрөө хүрэх үр дүн нь тодорхой, өмнөх сайн бүгдийг үгүйсгээгүй, улам сайжруулсан, эдийн засгийн болон бусад сайн үр дүнд хүргэх нь чухал. Энэ бүхнийг шинэчлэл эхлүүлэхийн өмнө түүнийг хэрэгжүүлэгчдийн болон хүлээж авах нийгмийн сэтгэхүйд ойлгуулах нь хамгийн чухал ажил болох ёстой юм. Харин тэдний сэтгэхүйд ойлгуулж чадаагүй тохолдолд хүч хөрөнгө, цаг хугацааг дэмий зарцуулсан ажил болно.

Бидний авч хэрэглээд байгаа инноваци гэдэг үг нь гарал үүслийн хувьд “in nova” буюу шинээр сэдэх, санаачлах гэсэн утгатай латин үг юм. Монгол Улсын Инновацийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт “инноваци” гэж шинэ мэдлэгийг баялаг болгон хувиргах цогц үйл явцыг;² ойлгоно гэж заасан. Шинэ мэдлэг бүтээх үйл ажиллагаа нь сэтгэлгээтэй шууд харилцан хамааралтай ойлголт.

Одоо уг үг салбар бүрт олон утгыг агуулдаг болсон. Жишээ нь эдийн засгийн салбарт инноваци гэсэн ойлголтыг аливаа шинэ бүтээмж, шинэ санааг эдийн засгийн эргэлтэд оруулж, мөнгө, хөрөнгө олох гэж ойлгож байна. Инновацийн үр нөлөө нь төрийн удирдлагын салбарт дэвшилтэт үр нөлөө авчрах шинэ буюу шинэчлэгдсэн үйлчилгээ, технологийн процесс, мөн удирдлага, зохион байгуулалт, санхүү, эдийн засгийн болон бусад шийдлүүдийг авчрах ёстой.

Инновацийг бүтээх гурван үндсэн шалтгаан байна гэж судлаачид үзсэн байдаг. Үүнд:

- Шинэ санаа, шинэ технологийг амьдралд хэрэглэх, хэрэгцээ
- Шинэ санаа, технологийг хэрэгжүүлэх мэдлэг чадвар бүхий хүн, технологи
- Шинэ санааг олон түмэнд хүргэхэд үзүүлэх эдийн засгийн дэмжлэг

Дээрх шалтгаануудад шинэ санаа гэсэн ерөнхий нэг шалтгаан байна. Шинэ санаа хэнээс гарах вэ гэхээр шинэ сэтгэлгээтэй мэргэжилтэнгүүдээс юм.

Хууль сахиулах үйл ажиллагааны шинэчлэлд хүний нөөцийн бодлого хамгийн чухал. Тэр тусмаа удирдах боловсон хүчин, мэргэжилтнүүдийн талаарх бодлогыг улс төрөөс ангид мэргэжлийн хүнийг эрхэмлэх чиглэлд барих нь уриаг жинхэнэ ажил болгох эхлэл юм.

¹Г.Оюунболд. Хууль сахиулах үйл ажиллагааны шинэтгэл илтгэл. Хууль сахиулахуй сэтгүүл. №1. УБ. 2014, 8 дахь тал

²Монгол Улсын Инновацийн тухай хууль. 2012. <http://www.legalinfo.mn/law/details/8668?lawid=8668>

Манай улс даяарчлагдсан дэлхийн ардчилсан улс болхын хувьд улс орнуудын тэргүүний туршлагыг судлах нь зүйн хэрэг боловч аль нэг орны шинэчлэлийн талаарх үзэл баримтлал, технологийг шууд орчуулгын түвшинд хэрэглэх нь тусгаар тогтносон улс орны үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөлж болох үйл ажиллагаа. Бид шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэхдээ өөрийн орны мэргэжилтнүүд дээр тулгуурлаж өөрсдийн шүүлтүүрээр шүүх нь хамгийн чухал юм.

Хууль сахиулах салбаруудаас шинэчлэлийг өргөн хүрээнд, эрчимтэй хэрэгжүүлж байгаа салбар бол Хууль Сахиулахын Их Сургууль юм. Цагдаагийн байгууллага ч шинэчлэгчдийн тэргүүнд явж байна. Цагдаагийн албаны тухай хууль, дагаж мөрдөх журмын тухай хуулиуд батлагдан, мөрдөгдөж эхэллээ.

“Цагдаагийн алба хаагчдын дунд сэтгэлгээний өөрчлөлт бий болгох нь энэ илтгэлд дурьдсан шинэчлэлийн асуудал бүрээс хамгийн чухал, мөн хамгийн их цаг хугацаа, хөрөнгө мөнгө шаардсан асуудал юм”³ гэсэн нь цагдаад шинэчлэл хийх арга замаа зөв тодорхойлсон байна гэж үзэж болхоор байна.

Хууль Сахиулахын Их сургуулийн Цагдаа судлалын төвийн 2013 оны “Цагдаагийн алба хаагчийн ёс зүй, үйл ажиллагааны орчин, түүний шинэтгэл” судалгааны тайланд “Шат шатны удирдах ажилтны тоог аль болох цөөлөх, дунд шатны удирдах /ахлах, чиглэлийн ахлах, хэсэг, тасаг, хэлтсийн дарга нар/ ажилтны чанар чансаа, сэтгэлгээ, ажилдаа хандах хандлагыг өөрчлөх, тэднийг чадавхжуулах”⁴ гэсэн дүгнэлт, санал зөвлөмжийг дэвшүүлсэн байна.

Аль нэг салбарын шинэчлэлийн үр дүн нь тухайн улс орны иргэдэд сайн үр дүн авчирч байх ёстой. Улс орны салбарууд нэг нь нөгөөгөөсөө ямарваа нэг байдлаар хамаарч байдаг учир шалтгаантай нь хувьд аль нэг салбарын хямрал нь бусад салбарт гинжин урвалаар нөлөөлөх нь гарцаагүй.

Аливаа салбарын шинэчлэлд хамгийн том саад болдог зүйл бол хүнд суртал ба хуучинсаг үзэл юм. Хүнд суртал, хуучинсаг үзлийг арилгахгүйгээр хууль сахиулах үйл ажиллагаанд шинэтгэл хийх нь хэтэрхий бэрхшээлтэй байх бөгөөд шинэтгэлийг эхлүүлэгч, хэрэгжүүлэгчийн төлөвлөсөн үр дүнд хүрэхгүй байх эрсдэлтэй.

Тэгвэл хүнд суртал хаана оршин байна вэ гэхээр хууль сахиулагчдын сэтгэхүйд л оршин байдаг. Тэдний сэтгэлгээ, сэтгэхүйд өөрчлөлт хийх нь хууль сахиулах үйл ажиллагаанд шинэчлэл хийх эхний ажил байх ёстой.

Шинэчлэлийг ганц хүн хийж чадахгүй, хууль батлан гаргаад ч төдийлөн үр дүнд хүрэхгүй, харин хууль сахиулагчдын болон тэдгээрийн үйл ажиллагааг гаднаас нь харж байдаг нийгмийн сэтгэлгээг шинэчлэх ажил өрнүүлэх нь амжилтанд хүрэх алхам юм.

Үүнийг хэрхэн хийх вэ. Гүрж улсын нэгэн жишээн дээр авч үзье. Ажилладаггүй, авлигад идэгдсэн байгууллагад байдлыг сайжруулах ганц арга бол татан буулгаад цоо шинээр эмхлэн байгуулах явдал гэж үздэг Гүржийн өөрчлөн байгуулалтын жор энгийн бөгөөд тун ойлгомжтой.

Бидэнд сайн сайхныг хүсдэг, шинэтгэлийг алгуур, дэс дараатай явуулах нь зүйтэй гэж үздэг Европын улсуудын санал зөвлөгөөг бид сонсолгүй нэлээд бүдүүлэг байдлаар ганц хоногийн дотор ДЯЯ-наас 15 мянган ажилтныг халсан хэмээн тус яамны сайд Вано Мерабишвили 2008 оны аравдугаар сарын 16-нд Эрх чөлөө радиод өгсөн “Шинэ Гүржийн нүүр царай” ярилцлагандаа дурьдсан⁵.

Гүрж улсын дээрх жишээнээс дүгнэлт хийвэл тэд нийгмийн болоод хууль сахилагчдын сэтгэлгээнд нэлээн том цохилт өгсөн байна. Учир нь тэд улс гүрнийхээ хууль сахиулах салбарт томоохон шинэчлэл хийхийг зорьсонд байгаа юм.

Үнэндээ тухайн халагдсан боловсон хүчнүүдийн сэтгэлгээг шинэчлэх гэж оролдож цаг хугацаа, хөрөнгө мөнгө зарцуулснаас шинэ боловсон хүчнүүдийг сургаж авсан нь дээр хэмээн үзсэн нь илэрхий.

Хууль сахиулах үйл ажиллагаанд тухайн салбарын мэргэжилтэнгүүдийн сэтгэлгээний шинэчлэл чухам ямар байр суурьтай байх юм бол гэж та асууж байж болох юм. Тэгвэл энэ нь морь унаж ажил, албаа залгуулж байсан хүнд автомашин жолоодох арга, ур чадварыг зааж

³Ж.Ганбаатар. “Цагдаагийн байгууллагын шинэчлэл” илтгэл. Хууль сахиулахуй сэтгүүл. №1. УБ. 2014, 57 дахь тал

⁴Цагдаа судлалын төвийн 2013 оны судалгааны тайлан. Эмхэтгэл-1. УБ. 2014, 204 дэх тал

⁵Лариса Буракова. Гүрж яагаад чадав. УБ.2012 он. /орчуулагч Г.Батхүү/ 49 дахь тал

өгөхгүйгээр морийг нь хичнээн сайхан автомашинаар солиод ч нэмэргүйн нэгэн адил ухагдхуун юм.

Шинэчлэл чухам яагаад хэрэгтэйг тухайн салбарын мэргэжилтэнүүдэд болон нийгэмд сайтар ойлгуулах ёстой. Өмнөх хууль сахиулах үйл ажиллагаа, эрх зүйн орчны сул тал нь юу байсан, яагаад заавал шинэчлэх шаардлага тулгарсан юм бэ гэж.

Хууль сахиулах үйл ажиллагааны шинэчлэл бол хэн нэгэн даргыг сольсноор хэрэгжих үйл ажиллагаа биш. Өмнөх хууль сахиулах тогтолцооны үед өндөр, дунд албан тушаал хашиж байсан дарга нарын арми шинэ тогтолцооны салхи дэгдэх үед шинэчлэгчийн багийг зүүсэн байх нь олон орны туршлагаас харж болох үзэгдэл юм.

Үнэндээ тэдний сэтгэлгээ шинэчлэгдэхээсээ илүү хуучин тогтолцоогоо хадгалж үлдэх сонирхол нь илүү давамгайлсан байдаг.

Хууль сахиулах үйл ажиллагааны шинэчлэл нийгэмд бодитоор мэдрэгдэж байх ёстой. Тухайн салбар өөрийн гэсэн онцлогтой бөгөөд мэдлэгээс гадна практик туршлагаар хэрэгждэг.

Практик туршлага бол уламжлал бөгөөд үүнийг шинэчлэлтэй зохистой харьцаагаар нь хослуулах нь зүйтэй. Гэхдээ зөв практик дээр анхаарал хандуулах нь чухал болхоос зөвхөн албан тушаал нэр хүндийн төлөө ажлыг цаасан дээр хийж сурсан хуучин дарга нарын арми дээр суурилж огтоос болохгүй юм.

Тэд хууль сахиулах үйл ажиллагаанд шинэчлэл хийсэн дүр эсгэхийн тулд ажлыг улам л илүү цаасан дээр явуулж эхэлнэ. Энэ нь хууль сахиулах үйл ажиллагааны шинэчлэлд өдрөөс өдөрт тээг, тушаа болно. Эрүүлээр сэтгэж буй шинэ залуу үеийг ч мөхөөн хордуулах аюултай.

Тэдний сэтгэлгээ шинэчлэгдэхээсээ илүү хуучинтайгаа зууралдаж, өөрсдийнхөө байр суурийг хамгаалж үлдэх сонирхолтой байдгийг огт мартаж өсгүй.

Ер нь сэтгэлгээний шинэчлэл гэж юуг хэлээд байна вэ? Энэ хэтэрхий хуучинсаг, эсвэл тэдний сэтгэлгээ огт шинэчлэгдэхгүй байна гэж ярьцгаадаг. Сэтгэлгээний шинэчлэл бол юу зөв юу бурууг ялгаж чадах, өөрийн чадвар, боломжийг таньж мэдэх оюун дүгнэлт байж болох юм.

Сэтгэлгээний шинэчлэл бол зөвхөн удирдах бүрэлдхүүнд хамаатай зүйл биш. Нийт бүрэлдхүүний ихэнх хэсгийг бүрдүүлдэг жинхэнэ хууль сахиулагчдад илүү хамаатай. Гүрж улсад болсон бодит зүйлийг жишээ болгон авч үзье.

2005 оны гуравдугаар сараас Байгаль орчны дэд сайд, 2007-2008 онд сайдаар ажилласан Давид ярьсан нь: "Өөрсдийн хийдэг ажлаа ганц хуудсанд багтаан бичихийг эхлээд газрын дарга нараас бид хүссэн. Тэд аль болох их зүйл бичихийг хичээж, тэр нь хэнд ч ойлгогдхооргүй болох байсан тул яг л ганц хуудсанд багтаахыг зориуд анхааруулж нэгээс илүү хуудсыг хүлээж авахгүй гэж мэдэгдсэн. Үүний дараа зарим газар де факто байдаггүй нь мэдэгдсэн.

Мэдээжийн хэрэг халахад амаргүй боловч нөгөө талаар эрүүл хүнийг өвчтэй хүнтэй нийлүүлэхэд өвчин халдварлаад эрүүл нь ч амьд үлдэхээргүй байлаа"⁶ гэжээ.

Энэ нь сэтгэлгээний хувьд өвчилсөн хүмүүсийн талаар хэлсэн хамгийн чухал жишээ бөгөөд шинэчлэгдэх нь байтугай тэд бусдыгаа ч сэтгэлгээний хувьд өвтгөх нь тодорхой гэдгийг хэлжээ.

Сэтгэлгээний хувьд эрүүл хүний нөөцтэй байх нь хууль сахиулах үйл ажиллагааны шинэчлэлд хамгийн чухал хүчин зүйл юм.

Монгол Улсын Инновацийн тухай хуулийн 8 дугаар зүйлд Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь инновацийн чиглэлээр хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах бүрэн эрхтэй гэж заасан нь хууль сахиулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх мэргэжилтэнүүдийг бэлтгэх эрх зүйн үндэс бүрдсэн.

2013 онд ухаалаг төр цогцлоон бүтээх уриан дор хуулийн засаглал, ил тод нээлттэй, иргэдийн оролцоотой, аюулгүй нийгмийг бий болгон, илүү зардлыг хэмнэх, ажил үүргийн давхардлыг арилгах, төрийн албанд хууль бус томилгоо хийхийг хязгаарлах, ухаалаг албатаар хүний нөөцийг бүрдүүлэх зарчмын асуудлууд тавигдаж эхэллээ⁷.

⁶Мөн бүтээл. 43-44 дахь тал.

⁷"Том төрөөс ухаалаг төр лүү" Үндэсний зөвлөлдөх уулзалтад Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн хийсэн танилцуулга, 46 дахь тал, 2013 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр, Төрийн ордон.

Ерөнхийлөгчийн ухаалаг албатаар хүний нөөцийг бүрдүүлэх хэмээн тодотгон хэлсэн нь шинэчлэлийг дэмжих, хүлээн авах чадвартай, чадварлаг шинэ үеэр хүний нөөцийг бүрдүүлэх нь зүйтэй гэсэн жирийн судлаачийн энэхүү судалгаанд томоохон түлхэцийг өгсөн юм.

Дүгнэлт, зөвлөмж:

Хууль сахиулах үйл ажиллагааны шинэчлэлд хүний нөөцийн сэтгэлгээний шинэчлэл нь томоохон байр суурийг эзлэх нь гарцаагүй тул:

- Хүний нөөцөд чиглэсэн яагаад хууль сахиулах үйл ажиллагааг шинэчлэх ёстойг ухуулан ойлгуулах хөтөлбөр боловсруулж үе шаттайгаар хэрэгжүүлэх
- Хууль сахиулах салбарын хүний нөөцийн бодлогод ухаалаг ажилтан гэсэн томъёолол, шалгуур бий болгох
- Хууль сахиулах үйл ажиллагааны шинэчлэлийн алсын харааг ойлгомжтойгоор тодорхойлох
- Тухайн салбарын хүний нөөцийн бодлогыг ил тод, тунгалаг болгох
- Шинэчлэлд эргэлзээ төрүүлэх бүх үйл ажиллагааг урьдчилан тооцож, засаж залруулах
- Шинэчлэлийг түүнийг ойлгосон, хэрэгжүүлэх чадвартай, сэтгэлгээний хувьд шинэлэг багаар удирдуулан хийлгэх нь зүйтэй.
- Эцэст нь “Хэн ч хянаж, хараагүй байхад ажлаа сайн хийсээр л байхыг чанар гэнэ” хэмээсэн Хенри Фордын алдарт ишлэлээр нийтлэлээ төгсгө.